

“Хуурмаг булчирхайт ортууз (*Oxytropis pseudoglandulosa* gontsch) ургамлыг хээрийн нөхцөлд үрээр тарималжуулах нь”

Б.Баасанжав¹, Б.Дэнсмаа¹, Г.Гантогтох¹, Н.Орхон¹

¹Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль

¹Эм Судлалын хүрээлэн

e-mail: baju.1225@yahoo.com

“The Agrothechnical Cultivation Method for *Oxytropis Pseudoglandulosa* Gontsch in Steppe Area Using it's a Seed”

B.Baasanjav¹, B.Densmaa¹, G.Gantogtokh¹, N.Orkhon¹

¹Mongolian University of Pharmaceutical Sciences

¹Drug Research Institute

e-mail: baju.1225@yahoo.com

Abstract

Oxytropis is an important genus of the family *Fabacea* and subfamily *Papillionoideae*. About 99 *Oxytropis* species could be found in Mongolian land and *Oxytropis pseudoglandulosa* is endemic species of Mongolia. Pharmacological research of this plant showed anti-tumor, antisepticise, anti-inflammatory, hemostasis, neuroendocrine system effects and immune suppression activities. Phytochemical studies resulted to isolation of a lot of chemical compounds like alkaloids, flavonoids, saponins, lignans, volatile compounds and polysaccharides. Plants of the genus *Oxytropis* afford complex constituents, and many of them have been used in traditional folk medicine throughout the world. Phytochemical investigations led to the 127 components including flavonoids, alkaloids and saponins, etc. Some crude extracts and chemical constituents of the genus *Oxytropis* were found with significant biological and pharmacological activities.

We worked on classification study of *Oxytropis pseudoglandulosa*. After the classification study, goal of this study is to develop agro technological cultivation method and cultivation *Oxytropis pseudoglandulosa* in experimental field instead of prepare raw material from wild herbals.

We seem that both of wild and cultivated of *Oxytropis pseudoglandulosa*'s seed can be use as main raw material for this plant. In case of cultivation of this plant in the experimental field, the seed should be harvested from field in end of June and all vegetative development stage completed. Therefore the experimental field also has to equip with water canal and protect from wind and has a smooth surface.

Key words

Endemic, classification, aerial part, soil, seed, vegetative.

Удиртгал: Хуурмаг булчирхайт ортууз ургамал нь Буурцагтаны (*Leguminosae*) овог, Ортууз (*Oxytropis*) - ын төрөлд хамаарагдах бөгөөд биологийн идэвхит бодис агуулсан, ортууз ургамлыг түүхий эдийг эмийн үйлдвэрлэлд хэрэглэдэг¹⁰.

Бид ургамлын түүхий эдийг үйлдвэрлэлийн хэмжээнд бэлтгэж хэрэглэхийн тулд ортуузын байгалийн нөөцийг хамгаалах зорилгоор тарималжуулах шаардлагатай болсон. Хуурмаг булчирхайт ортууз ургамалд агуулагдаж байгаа биологийн идэвхит бүтээгдэхүүний судалгааг манай улсын эрдэмтэн судлаачид нилээд судалсан. Ортууз ургамлын түүхий эд нь амны хөндийн салст бүрхүүл улайх, шүдны орчмын болон буйлны үрэвслыг анагаах зэрэг ач холбогдолтой⁸.

Байгалийн ургамлыг хайрлан хамгаалах, нөөцийг нь тогтоох, нөхөн сэргээх, генефондыг хамгаалах нь байгаль судлаачдийн үүрэг хариуцлага байдаг.

Зорилго: Бид Хуурмаг булчирхайт ортуузыг өндөр уулын хээрийн бүсэд тарималжуулан тариалах аргачлалыг боловсруулах зорилго тавин ажиллаа.

Түлхүүр үг: Ортууз ургамал, ангилалзүй, хөрс, үр, тарималжуулалт

Судалгааны материал аргазүй: Богд хан уулын “Төр хурхын ам”-ны байгалийн ургамлаас ортууз ургамлын үрийг авч, тарих эх материалыг бэлдсэн бөгөөд ургамал тарималжуулах аргазүйн дагуу тарималжуулах судалгааг хийж гүйцэтгэсэн.

Судалгааны ажлын үр дүн: Бид ортууз ургамлыг үрээр тариалах арга зүйг боловсруулсан бөгөөд дараах байдлаар тарималжуулах ажлыг гүйцэтгэнэ.

1. Хуурмаг булчирхайт ортуузын тарих эх материал /үр/ бэлтгэх: Хуурмаг булчирхайт ортууз (*Oxytropis pseudoglandulosa* gonttsch) - ын тарих эх материалыг байгалиас түүсэн үр ба тарималжуулсан ургамлын үрийг хэрэглэж болно. Ургамлын үрийг түүж бэлтгэхдээ ургамлын хөгжлийн үе шат нь бүрэн явагдаж дуусан үед буюу 7-р сарын сүүлээр ургамлын үрийг түүж бэлтгэдэг.

Ургамлын тариалалтыг үрээр хийх учраас хөрс нь тэгш гадаргуутай, суваг шуудуу татаж гадаргуугийн усалгаагаар услахад өөрийнхөө урсгалаар услагдах бололцоотой, салхины нөлөөнөөс хамгаалагдсан байхаар талбайг бэлдэнэ.

Үрийг бүрэн боловсорсон үед нь салхи болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр газарт унаж гээгдэхээс өмнө түүж авна.

2. Хөрс боловсруулах: Тариалалтыг үрээр хийх учраас хөрс нь тэгш гадаргуутай, суваг шуудуу татаж гадаргуугийн усалгаагаар услахад өөрийнхөө урсгалаар услагдах бололцоотой, салхины нөлөөнөөс хамгаалагдсан байхаар талбайг сонгож авна. Тарихын өмнөх хөрс боловсруулалт нь тарилт хийх чиглэлийнхээ эсрэг байвал их тохиромжтой бөгөөд талбайг тэгшлэн үрийг жигд гүнд суух нөхцөлийг бүрдүүлнэ. 10*3

м² хэмжээтэй хайрцаглан, хайрцаг хооронд усалгааны шуудуу гаргах ба ургамлын үрийг жигд суулгахаар бодож талбайг засах бөгөөд талбайн аль ч хэсэгт ус жигд хүрж байхаар хөрсийг тэгшлэн боловсруулна.

- 3. Тариалах:** Хуурмаг булчирхайт ортууз ургамлын тарих хугацаа нь бидний судалгаагаар хөрсний 0-15 см гүнд 5⁰С дээш дулаантай болсон үед V/10-20-ны хооронд тарих нь тохиромжтой болох нь харагдлаа. Тохирсон гүнд үрийг суулгах нь тарилтын чанарын нэг гол асуудал юм.

Ургамлын үрийг тарихдаа урьдчилан бэлтгэсэн талбайд мөр хооронд 25-30 см зайтай, хос эгнээгээр, эгнээ хооронд 10-15 см зайтай, 1,5-2.0 см гүнд сийргээр туузлан үрийг жигд суулгаж тарина.

- 4. Усалгаа:** Үрийг тарьсны дараа урсгалын хурд багатай усаар хөрсийг нэвчүүлэх маягаар усладаг. Ургалтын эхний үедээ хөрс өнгөн хэсэгтээ чийгтэй байхыг шаарддаг. Ийм учир ургалтын эхний жилд түүний дотор эхний саруудад усаар дутааж болохгүй. Хуурмаг булчирхайт ортууз нь чийг шаарддаг ургамал. Ургалтын хугацаанд 5-7 удаа услах бөгөөд намрын цэнэг усалгааг сайн хийж өгөхөд хөрсөндөө сайн өвөлжиж дараа хавар дулаан байвал нахианы сэргэлт эрт явагддаг.

- 5. Агро арчилгаа:** Хуурмаг булчирхайт ортууз ургамал нь олон наст өвслөг ургамал учир эхний жилүүдэд хог ургамалд амархан нэрвэгддэг онцлогтой. Иймд үрийг цухуйн гарч мөр тодрох үед мөр хоорондын хог ургамлыг устгаж, цухуйц бүрэн жигдэрсний дараа ургамал хоорондын хог ургамлыг түүвэрлэн түүнээс хойш хог ургамлыг байнга устгаж, усалгаа бүрийн дараа хөрсийг сийрүүлж өгнө. Мөн өвчин, хортон шавж гарсан тохиолдолд цаг алдалгүй ургамал хамгаалах арга хэмжээг авна.

- 6. Өвөлжүүлэлт:** Хуурмаг булчирхайт ортууз нь X сарын эхээр агаарын температур буурахад ургамлын шинээр ургасан найлзуур үзүүрээсээ өнгө нь шарлаж хагдардаг. Талбайд тарьсан ургамлыг 10-р сарын дундуур их нормоор, хөрсийг нэвчтэл усална. Намрын цэнэг усалгаа нь ургамлыг өвлийн улиралд өнтэй давах төдийгүй дараа хавар нахианы сэргэн ургалтанд, чийгийн хангамжинд чухал ач холбогдолтой байдаг. Ямар нэгэн нэмэлт хучлага хэрэглэхгүй өвөлжүүлж болно.

Дүгнэлт: Бид Хуурмаг булчирхайт ортууз ургамлыг үрээр тарималжуулах судалгааг хийж, судалгааны үндсэн дээр тухайн ургамлын тариалах агро аргачлалыг боловсруулаа. Энэхүү аргачлалын дагуу хуурмаг булчирхайт ортуузыг үрээр тарих боломжтой гэж үзэж байна.

Ашигласан хэвлэлийн жагсаалт:

1. Грубов В.И. Монгол орны гуурст ургамлын таних бичиг. УБ. 2008 он.
2. Ганчөдөр Ц., Итгэлт Н. Монгол орны нөхцөлд хөрс хамгаалах ойн зурвасны ач холбогдол. Байгаль орчин амьдрал сэтгүүл. УБ, 2010
3. Ганчөдөр Ц., Хауленбек А. Цөлжилттэй тэмцэх технологийн туршилт судалгаа. Биологийн нөхөн сэргээлт, онол-практикийн анхдугаар хурал. УБ, 2011. 90-97.
4. Ганчөдөр Ц., Хауленбек А. Тал хээр нутагт мод, сөөг ургамлыг тарималжуулах хугацааг зөв сонгох асуудал. УБ, 2011
5. Даш Д., Монгол орны ландшафт – экологийн асуудлууд. УБ, 2010. 80-87.
6. Доржготов Д. Монгол орны хөрс. УБ, 2003. 155-183.
7. Дашзэвэг Ц., Жалбаа Х. “Монгол орны ойн нөөцийг хамгаалах нөхөн сэргээх үндэслэл” төслийн 1999-2000 онд хийсэн эрдэм шинжилгээний ажлын тайлан. УБ, 2000. 55-77.
//Эх бичмэлээр Геоэкологийн хүрээлэнгийн архивт бий
8. Лигаа У., Даваасүрэн Б., Нинжил Н., “Монгол орны эмийн ургамлыг өрнө дорнын анагаах ухаанд хэрэглэхүй”. УБ. 2015 он.
9. Өлзийхутаг.Н. Монгол орны ортуузын төрлийн ургамал /Ангилал зүй, тархац, экологи, түүхэн хөгжил, аж ахуйн ач холбогдол/ БНМАУ-ын ургамлын аймаг, ургамалжилтын судалгаа.Тэргүүн боть. УБ.1979
10. Urgamal M., Oyuntsetseg B., Nyambayar D., Dulamsuren Ch., “Conspectus of the vascular plant of Mongolia” UB. 2014.
11. <http://www.mne.mn/mn/582>

Танилцаж нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор Б.Цэрэндолгор